

ЗӨРЧИЛ СУДЛАЛЫН ТӨВ

*Д.Золбоо**

Энэ оны 6-р сард түүхч, академич Ч.Далай, түүхийн ухааны доктор С.Дамдинсүрэн, Л.Хайсандай зэрэг ШУА-ийн нийгмийн ухааны эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн нэртэй зүтгэлтнүүд, залуу эрдэмтэн судлаачид болон сэтгэл зүйчид хамтраад Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дэргэд “Зөрчил судлалын төв” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагыг байгуулсан байна.

Энэ төв нь Монголд зөрчил судлалыг хөгжүүлэхэд судлаач мэргэжилтнүүдийн хүчийг нэгтгэх, энэ салбарт өөрсдийн хувь нэмрээ оруулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, залуу эрдэмтдийг дэмжих болон залууст амьдралд тулгарах аливаа зөрчлийн асуудлыг шийдвэрлэхэд туслах сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилготой ажээ. Мөн түүнчлэн гадаад дотоодын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах юм байна.

Орчлон дэлхийн аливаа юмс үзэгдэл нь өөр хоорондоо нэгдэлдэн оршихийн зэрэгцээ зөрчилдөн тэмцэлдэж байдаг философийн хуулийг бид бүхэн мэдэх билээ. Тиймээс ч өнөөгийн дэлхий дахинд тэр дундаа Өрнийн улс гүрнүүдийн нийгмийн шинжлэх ухааны салбарт “Conflictlogy” буюу Зөрчил судлал гэсэн шинэ салбар үүсэн бий болоод багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд нэлээд хөгжжээ. Энэ талын судалгаа манай оронд албан ёсоор хараахан хөгжиж эхлээгүй байгаа бөгөөд нийгмийн аливаа асуудал тэр дундаа олон улсын харилцаа, гадаад боллого зэрэг сэдвийн судалгаа шижилгээний ажилд энэхүү онолын судалгааны үр дүнг оролцуулбал арай илүү бодит байдалд дөхөж очих төдийгүй, үр дүн нь дээшлэх бизээ. Хамрах хүрээний хувьд нийгмийн доторх жирийн хүмүүсийн хоорондын харилцаанаас эхлээд өнөөгийн дэлхий дахины хурцадмал асуудал болсон даяаршил, үндэстэн шашин хоорондын мөргөлдөөн, Ойрхи Дорнодын асуудал, Иракийн дайн, Хойд Солонгосын цөмийн хямрал, терроризмын асуудал зэрэг олон талбарт энэ талын судалгааны ажлыг өрнийн мэргэжилтнүүд өргөнөөр ашигласаар ирлээ. Манайд ч гэсэн зарим нэгэн судлаачид мэр сэр энэ талын асуудлыг хөндсөөр байдаг билээ.

Цаашид “Олон Улс Судлал” сэтгүүлийн хавсралт болгон өөрийнхөө сэтгүүлийг гаргахаар бэлдэж байгаа тул эрдэмтэн судлаач болоод сонирхсон хэн бүхнийг хамтран ажиллахыг урьж байна.

*Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр